

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### УЛСЫН АВАРГА МАЛЧИН, ХОШОЙ АВАРГА МАЛЧИН, ФЕРМЕР, СААЛЬЧИНД ОЛГОХ МӨНГӨН АЯГАНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Нэр:** Улсын аварга малчин, хошой аварга малчин, фермер, саальчинд олгох мөнгөн аяга

**Нийлүүлэх хэмжээ:** 168 ширхэг (нэг зуун жаран найм)

**Төсөвт өртөг:** 159,600,000.0 (Нэг зуун тавин есөн сая зургаан зуун мянга) төгрөг

№	Барааны техникийн үзүүлэлт	Барааны техникийн тодорхойлолтын үзүүлэлт, шаардлага	Санал болгож буй техникийн тодорхойлолт	Тайлбар нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана
1	“Ф-7 хэмжээтэй мөнгөн аяга”-д тавигдах ерөнхий шаардлага	Цалин цагаан мөнгө нь 999/925/ ийн хувийн сорьцтой, чанарыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан цулгуй мөнгөн аяга байна. Хэрэв дахин давтагдашгүй патенттай бол патент ирүүлэх. Аяган дээр захиалагчийн заасан байрлалд өгсөн бичээсийг алдаагүй бичсэн байна.		
2	Гарал үүсэл:	Монгол улс		
3	Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаяг	Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаягийг тодорхой бичиж ирүүлнэ.		
4	Үйлдвэрлэсэн он	2024 он		
5	Материал, хэмжээ, орц	- Амсарын хэмжээ 160 мм - Өндөр 45 мм - Аяганы эзэлхүүн 450 мл - Аяганд орсон нийт мөнгөний жин 135 граммаас доошгүй - Аяганы дотор орсон цагаан мөнгө 999 сорьц бүхий 75 граммаас доошгүй - Аяганы ёроолд нь 925 сорьцтой (таван хошуу мал,		



		бадамлянхуаг товойлгон цутган суулгасан байна.) - Аяганы дотор хэсэгт 999 сорьцтой (таван хошуу мал, улсын аварга малчин, хошой аварга малчин, саальчин, фермер 2023 он гэсэн лазер бичигтэй байна.) - Аяганы бөөр хэсэгт 12 жилийн дүрсийг товойлгон хийнэ.		
6	Савлалт, хадгалалт, хэрэглээ	Тус бүрийг тусгай цаасан хайрцаганд савласан байна.		
7	Бараа хүргэх газар	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. Захиалагч нэг бүрчлэн тоолон шалгаж хүлээн авна.		
8	Ачаа тээвэрлэх нөхцөл:	Барааг гүйцэтгэгч өөрийн тээврээр хүргэж ирнэ. Тээвэрлэлийн үед байгаль, цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан үзэж, алдагдах, гэмтэхээс урьдчилан сэргийлнэ.		
9	Эх бэлтгэх:	Гүйцэтгэгч аяганы хэмжээ загвар хийцийн шаардлага хангасан зураг, бүдүүвч хийх саналыг боловсруулж ирүүлнэ.		

#### БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Барааны нэр, тодорхойлолт	Тоо хэмжээ	Нийлүүлэх хуаарь
1	Улсын аварга малчин-145 ширхэг, хошой аварга малчин-8 ширхэг, фермер-9 ширхэг, саальчин-6 ширхэг мөнгөн аяга	168	2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн дотор
2	Тухайн үеийн Засгийн газрын шийдвэрээс хамаарч тоонд өөрчлөлт орсон тохиолдолд нэмэл гэрээ байгуулж болно.		Зөвшөөрсөн эсэх